



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

“Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн
өмчит үйлдвэрийн газрын 2021 оны эдийн
засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон
контрактын биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Засгийн газрын 2021 оны 345 дугаар тогтоолын 1.1 дэх заалт, “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал Я.Нямжаргалтай байгуулсан контрактын биелэлтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.“Эрчим хүчний хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал Я.Нямжаргалтай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001681